



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 4/634

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/487 тоот захирамжийн хавсралт-1-ийг хүчингүй болгосугай.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Мөрөн, Эрдэнэбулган сум/” барих ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

3. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.

4. Дээрх “Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Мөрөн, Эрдэнэбулган сум/” барих ажлын гүйцэтгэгч сонгох худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712011879

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр
сарын 14-ний өдрийн А/... дугаар
захирамжийн хавсралт

АХМАДЫН ӨРГӨӨНИЙ БАРИЛГА /ХӨВСГӨЛ, УЛААН-УУЛ, МӨРӨН, ЭРДЭНЭБУЛГАН
СУМ/ БАРИХ АЖЛЫН ХҮРЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Төсөвт өртөг	Батлагдсан төсөв /2024 он/
1	Ахмадын өргөөний барилга /Улаан-Уул сум/	480,000,000	
2	Ахмадын өргөөний барилга /Мөрөн сум/	480,000,000	432,000,000
3	Ахмадын өргөөний барилга /Эрдэнэбулган сум/	480,000,000	
Нийт		1,440,000,000	432,000,000

_____ооо_____